



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 12 өдөр

Дугаар 1/33

Чингис хот

Хэсгийн ахлагч, хүүхдийн эрхийн олон
нийтийн байцаагч ажиллуулах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт “Төсвийн тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.4, 20.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын мөрийн хөтөлбөрийг сурталчлах, хэрэгжүүлэх, багийн үйл ажиллагаанд туслах, нутаг дэвсгэрийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, мэдээлэх, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахад чиглэсэн санал санаачилга гаргаж хэрэгжүүлэх, хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, хүүхдийн эрхийн зөрчлийг шийдвэрүүлэх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий хэсгийн ахлагч, хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагч нарын тоог хавсралтаар баталж томилсугай.

2.Хэсгийн ахлагч, хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчдад олгох урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу төсөвт тусгасан дүнд багтаан тооцож олгохыг нягтлан бодогч (Д.Баярцэцэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
02 дугаар сарын 12-ны өдрийн 1/33
дугаар захирамжийн хавсралт

Хэсгийн ахлагч, хүүхдийн эрхийн олон
нийтийн байцаагч ажиллуулах хавсралт

№	Багийн нэр	Орон тоо
1	Хэрлэн 1-р баг	8
2	Булаг 2-р баг	8
3	Баянмөнх 3-р баг	8
4	Сариг 4-р баг	8
5	Өндөрхаан 5-р баг	8
6	Цогт-өндөр 6-р баг	2